



1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“Э-Транс Ложистикс” ХК нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалсны дараа хувь нийлүүлэгчдийн хурлаа зарлан дүрэм болон засаглалын журмуудыг хэлэлцэн батална. Иймээс “Э-Транс Ложистикс” ХК-ийн дүрмийн төсөл, “Ногдол ашиг хуваарилах журам”-ын төсөлд тусгасан хувьцаа эзэмшигчийн эрх, ногдол ашгийн бодлогын талаарх мэдээллийг оруулав.


Дүрмийн төсөлд:


- Компани нь жил бүрийн үйл ажиллагааны цэвэр ашгийг төсөвлөж зарцуулна. Үүнд: Урт богино хугацааны хөрөнгө оруулалт, компанийн ажиллагсдын нийгмийн асуудал, шагнал, урамшил, компанийн эрх бүхий албан тушаалтанд олгох шагнал урамшуулал, компанийн хувь нийлүүлэгч нарт олгох ногдол ашиг зэрэг болно.
- Компанийн жилийн цэвэр ашгийн 20-оос доошгүй хувийг ногдол ашигт хуваарилж байна.

“Ногдол ашиг хуваарилах журам”-д

Ногдол ашгийн бодлого

- Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.
- Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батлана.
- Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө танилцуулана.
- Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө, үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болно.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-н шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.





1.9. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ашгийн хэмжээг тодорхойлох

- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
- Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна.
- Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ногдол ашиг тараах тохиолдолд тухайн эд хөрөнгө, үнэт цаасны үнэлгээг ТУЗ-аас тогтооно.

Ногдол ашиг хуваарилах

- Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.
- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна.
- Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.
- Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаандаа ногдол ашгаа төлөх үүрэгтэй.

